



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,
Сүхбаатарын талбай-6,
Утас: 26-30-83, Факс: 26-12-73
E-mail: Office@president.mn

2021. 02. 24 № ТГ/113
таний —ны № —т

Г МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
ЦЭЦИЙН ГИШҮҮН Д.СОЛОНГО ТАНАА

Г Тайлбар гаргах тухай Т

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан иргэдийн мэдээлэлтэй холбогдуулан ирүүлсэн Таны 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 2/59 дугаар “тайлбар гаргуулах” тухай албан бичиг болон түүнд хавсаргасан баримт, мэдээлэлтэй танилцаа.

Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд:

- 3.1.2. “нэр дэвшигч” гэж 50 нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшин бүртгүүлж, нэр дэвшигчийн үнэмлэх авсан Монгол Улсын уугуул иргэнийг ойлгоно;
- 5.4. 50 нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан Монгол Улсын уугуул иргэн Ерөнхийлөгчөөр сонгогдох эрхтэй.
- 5.6. Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хууль бусаар хязгаарлах, сонгочоос саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хөндлөнгөөс нөлөөлөх, саад учруулахыг хориглоно.
- 26.2. Нэр дэвшигч хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна: 26.2.1. банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөргүй байх; 26.2.2. татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх, аль нэг компанийн 51 ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өргүй байх; 26.2.3. сэтгэцийн эмгэггүй байх зэрэг 1993 оноос хойших Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиуд болон 1992 оноос хойших Улсын Их Хурлын болон орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай /10 гаруй/ хуулиудад утга, агуулгын хувьд бүрнээ тусгагдаж, маргаангүй хэрэгжиж ирсэн зохицуулалтууд зарчмынхаа дагуу тусжээ.

Гэтэл нэр бүхий иргэд Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх ямар ч үндэслэл, боломжгүй дээрх хуулийн зохицуулалтуудыг хүчингүй болгуулахаар Үндсэн хуулийн цэцэд хандаж, 3.1.2-т заасан “нэр дэвшигч” хэмээх тодорхойлолтод Монгол Улсын иргэдээс “Х.Баттулга ганцаараа хамаарахгүй” гэж тусгайлан заагаагүй, 5.4-т заасан сонгогдох эрхийг Монгол Улсын иргэдээс “Х.Баттулга ганцаараа эдлэхгүй” гэж тухайлан бичээгүй, 5.6-д заасан “Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг

хууль бусаар хязгаарлахыг хориглоно” гэсэн хэсэгт “Монгол Улсын иргэдээс ганц Х.Баттулгын эрхийг хязгаарлаж болно” гэж тодотгон тусгаагүй, 26.2-т заасан нэр дэвшигчид тавигдах шаардлагад “Монгол Улсын иргэдээс ганц Х.Баттулга гэдэг хүн нэр дэвшиж болохгүй” гэсэн онцгой шаардлагыг оруулахгүй орхигдуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэх агуулгатай мэдээлэл гаргаж, Монгол Улсын нэг иргэний эрхийг бүрэн хааж, боох бүх л шаардлагыг хангасан хууль гаргахыг Улсын Их Хуралд даалгуулах утга бүхий шаардлага, хүсэлтийг тавьсан байна.

Нэр бүхий иргэдийн энэхүү мэдээллийг Үндсэн хуулийн цэц хүлээн авч, 28 жилийн тэртээгээс хэрэгжиж ирсэн, Үндсэн хуулийн шаардлага, суурь зарчмыг хангасан, хууль зүйн хувьд ямар ч маргаангүй хуулийн дээрх заалтуудыг энэ удаад хянан үзэж, Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан иргэнийг бүртгэхгүй байх шаардлагыг орхигдуулан хуульчилсан нь Үндсэн хууль зөрчсөн эсэхийг тогтоохоор маргаан шийдвэрлэх ажиллагаа үүсгэжээ.

Үүний хүрээнд асуудлыг нарийвчлан судалж үзэхэд нэр бүхий иргэдийн мэдээлэл, холбогдох бусад үйл ажиллагаа нь хэт нэг талыг барьсан, Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөв болон Жаран зургадугаар зүйлд заасан “Үндсэн хууль зөрчсөн тухай” гэсэн маш тодорхой үндэслэлийг онолын хувьд буруу ойлгож, хэрэглэсэн, зарим талаар улс төржсөн агуулга бүхий хүлээн зөвшөөрөх ямар ч боломжгүй асуудал, шийдэл, санаархлаар дүүрэн байгааг онцлон дурдах нь зөв гэж үзэж байна.

Тиймээс уг асуудлыг олон талаас нь бодитойгоор авч үзэж, Үндсэн хууль болон хууль зүйн шинжлэх ухааны онол, практикийн хүрээнд үндэслэл бүхий дор дурдсан тайлбарыг гарган хүргүүлж байна:

1. Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өмнө нь Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан иргэнийг бүртгэхгүй байх шаардлагыг орхигдуулан хуульчилсан гэх мэдээллийг гаргагч иргэдийн үзэл бодол, түүний хүрээн дэх үндсэн шаардлагууд нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах...” гэсэн чиг үүрэг болон харьялан шийдвэрлэх маргаан, цэцийн эрх хэмжээнд хамааралгүй байна.

Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлээс гадна Жаран зургадугаар зүйлд тухайлан зааснаар зөвхөн Улсын Их Хурлын баталсан хуулийн үг, өгүүлбэр Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянах эрхтэй. Өөрөөр хэлбэл “батлагдсан хуульд ямар үг, өгүүлбэр байх ёстойг тогтоох, орхигдсон эсэхийг хянах, ийм үг, өгүүлбэртэй хууль гарга хэмээн Улсын Их Хуралд даалгах” эрх Үндсэн хуулийн цэцэд байхгүй юм.

Нэр бүхий иргэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд “өмнө нь Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байгаагүй байх гэсэн шаардлагыг орхигдуулсан” нь “Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан болон ажиллаж байгаа иргэнийг Ерөнхийлөгчид дахин нэр дэвшихийг зөвшөөрсөн мэт агуулгатай” байна хэмээн үзэж, мэдээллийнхээ гол агуулгыг хуулийн 3.1.2 дахь заалт болон 5.4, 5.6, 26.2 дахь хэсгүүд Үндсэн хууль зөрчсөн тухайд бус, харин уг заалт, хэсэгт байх ёстой гэж өөрсдийн

үзсэн тодорхой шаардлагыг Улсын Их Хурал хуульчлаагүй /эс үйлдэхүй гаргасан/ гэж маргажээ.

Тодруулбал нэр бүхий иргэд Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөл, мэдээлэлдээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дурдагдаж буй заалтууд, түүний бичвэр (текст) нь Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг хэрхэн зөрчсөн талаар тодорхой үндэслэл, шаардлага огт тусгаагүй байх бөгөөд тухайн иргэд хуулийн дээрх зүйл заалтуутай холбогдуулан өргөдөл, мэдээлэл гаргаагүй, гагцхүү хууль тогтоогч “эс үйлдэхүй” гаргасан гэж үзэж, түүнд холбогдуулан өргөдөл, мэдээлэл гаргасан нь үүгээр батлагдаж байна.

Монгол Улсын Үндсэн хууль хэм хэмжээний негатив хяналтыг шууд хэрэгжүүлэх эрх хэмжээг Үндсэн хуулийн цэцэд олгоогүй бөгөөд өөрөөр хэлбэл хууль тогтоогчийг “эс үйлдэхүй” гаргасан хэмээн үзэж, тэрхүү “эс үйлдэхүй”-г хууль бус болохыг тогтоолгох үндсэн шаардлагын хүрээнд гаргасан өргөдөл, мэдээллийг хүлээн авч, маргаан үүсгэж, хянан шийдвэрлэхийг Үндсэн хуулийн цэцэд зөвшөөрөөгүй болно.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн хавсралт хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуульд тодорхойлсон хүний эрхийг дордуулсан заалт бүхий БНМАУ-ын хууль болон олон улсын гэрээ, тэдгээрийн заалтыг мөнхүү Үндсэн хууль хүчин төгөлдөр болсноос хойш хэрэглэхийг хориглоно” гэж заасан бөгөөд тус хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэхүү Хавсралт хууль Монгол Улсын Үндсэн хуулийнхаа нэгэн адил хүчинтэй” гэж зааснаар 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш өнөөг хүртэл, мөн түүнчлэн ирээдүйд ч Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг дордуулсан хуулийг батлахаас эгнэгт татгалзах нөхцөл бүрдэж, үүнд нь хяналт тавих Үндсэн хуулийн механизм бий болсон юм.

Тухайлбал Улсын Их Хурал иргэний үндсэн эрхийг хязгаарласан буюу дордуулсан хуулийг баталсан тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуулийн манаач болсон Үндсэн хуулийн цэц ийм хууль, түүний зүйл, заалтуудыг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянан үзэж, хөндлөнгийн дарамт, нөлөөгүйгээр тухай бүр магадлан шийдвэрлэсээр ирсэн.

Нэр бүхий иргэдийн маргаан үүсгээд буй энэхүү асуудлыг ч мөн Үндсэн хуулийн цэц 1997 онд эцэслэн шийдвэрлэж, хууль зүйн хувьд ямар ч эргэлзээгүй бөгөөд маргаангүй болгосон байдаг.

Тодруулбал 1992 оноос 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэл мөрдөгдөж ирсэн Үндсэн хууль Монгол Улсын Ерөнхийлөгчид нэг хүн 2 удаа нэр дэвшихийг зөвшөөрч байсан бөгөөд 1990 онд Монгол Улсын анхны Ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан П.Очирбат гуай 1993 онд шинэ Үндсэн хуулийн дагуу нэр дэвшин сонгогдож, 1997 онд дахин нэр дэвшихэд 3 дахь удаагаа нэр дэвшлээ гэдэг маргаан үүсэж, уг маргааныг Үндсэн хуулийн цэц 1997 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар дүгнэлтээрээ Үндсэн хууль зөрчөөгүй хэмээн шийдвэрлэж, П.Очирбат гуайг дахин нэр дэвших эрхтэйг тогтоожээ.

Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар дүгнэлт өнөөдөр ч хүчин төгөлдөр юм.

3. Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан иргэний сонгох, сонгогдох эрхийг баталгааг дордуулаагүй бөгөөд Үндсэн хууль болон түүний Хавсралт хууль, 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан нэмэлт, өөрчлөлт, түүнийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн холбогдох зүйл, заалтад бүрнээ нийцсэн гэж үзэж байна.

Үндсэн хуулийн цэцэд өргөдөл, мэдээлэл гаргагч иргэд Үндсэн хуульд заасан иргэний “сонгох, сонгогдох” үндсэн эрхийг дордуулсан хууль гаргасангүй гэж хууль тогтоогчийг буруутган, “эс үйлдэхүй” гаргасан хэмээн үзэж, үүнийгээ Үндсэн хуулийн цэцээр нотлуулан баталгаажуулахыг хүсэж байгаа нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсгийг шууд зөрчихөд хүргэхээс гадна Монголын ард түмний “эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх” Үндсэн хуулийн эрхэм зорилгод үл нийцэж байна.

Үндсэн хуулийн Хавсралт хуулийн дээр дурдсан зүйл, заалтууд, түүнчлэн Үндсэн хуулийн Хорь дугаар зүйлд заасан хууль тогтоогчийн онцгой бүрэн эрхэд халдах, улмаар Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээнд хамаарахгүй асуудлаар шийдвэр гаргуулахыг хүсэх, Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг болон Жаран зургадугаар зүйлийг тус тус зөрчин шийдвэр гаргахыг Үндсэн хуулийн цэцээс шаардах зэрэг нь Үндсэн хуулийн эрх зүйн үндэслэлгүй, зүй бус шаардлага болно.

Үндсэн хуулийн цэц өнгөрсөн 30-аад жилийн хугацаанд иргэний үндсэн эрхийн Үндсэн хуулийн баталгааг сайжруулах чиглэлээр Үндсэн хуулийн хяналтыг тавьж ирсэн жишигтэй байна. Үндсэн хуулийн цэц өнөөдөр үүнийгээ үгүйсгэж, Монгол Улсын иргэний үндсэн эрхийг зөрчих зүй бус зорилго, ёс бус ашиг сонирхолд үйлдэл, эс үйлдэхүйгээрээ дэмжлэг үзүүлж эхэлбэл эрх зүйт төрийг төлөвшүүлэх үйл явц мухардалд орж, хүний үндсэн эрхийн баталгаа шууд алдагдахад хүрнэ.

4. Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд зааснаар хууль тогтоох эрх мэдэл гагцхүү Улсын Их Хуралд хадгалагдах бөгөөд хууль тогтоогчийн энэхүү онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шийдвэрт үндэслэлгүйгээр халдах эрхийг хэнд ч олгоогүй юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг Улсын Их Хурал өөрийн онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан бөгөөд өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байна. Түүнчлэн Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль товлон зарлагдаад байна.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр орсон нэмэлт, өөрчлөлтийг батлагдахад Ерөнхийлөгч Х.Баттулга тэргүүлэх үүрэгтэй оролцож, Улсын Их Хурлын 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 72 дугаар тогтоолоор байгуулагдсан, тухайн үеийн Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга

Д.Тогтохсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Эрдэнэбат, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Θ.Энхтувшин, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хөргийн сайд Ц.Нямдорж, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэ, Л.Болд нарын бүрэлдэхүүнтэй, зөвшилцлийн Ажлын хэсгийн даргаар ажилласан.

Ерөнхийлөгч Х.Баттулга зөвшилцлийн Ажлын хэсгийг даргалж ажилласнаас гадна Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд гарын үсгээ зурж, ёсчлон баталгаажуулсан болно.

Ийнхүү батлагдсан нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уuguул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно” гэсэн өөрчлөлт орсон байdag.

Энэхүү өөрчлөлт нь нэр бүхий иргэдийн тавьж буй шиг маргаантай асуудал огт үүсгэхгүй, Үндсэн хуулийн суурь зарчим, иргэний үндсэн эрхийн баталгааг алдагдуулахгүй, Монгол Улсын иргэд эрхэлсэн ажил, албан тушаалаараа ялгарлагдахгүйгээр хуулийн өмнө эрх тэгш байж, сонгогдох эрхээ хэрэгжүүлнэ гэдгийг хууль тогтоогч тодорхой тайлбарлаж, залгамж бүхий үйл ажиллагаа, шийдвэрээрээ бүрнээ нотолсоор ирсэн.

Тухайлбал Үндсэн хуулийн өөрчлөлт Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан болон ажиллаж байгаа хүний үндсэн эрхийг хязгаарлахгүй, үүний дотор Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэр дэвших эрхтэй гэдгийг хууль тогтоогчийн хувиар мэдэгдсэн зөвшилцлийн Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн, тухайн үеийн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, өдгөө Хууль зүйн байнгын хорооны даргаар ажиллаж байгаа С.Бямбацогтын тайлбар нийтэд ил байдаг бөгөөд энэ нь албан ёсны байр суурь юм. Мөн зөвшилцлийн Ажлын хэсгийг даргалж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд гарын үсгээ зурж, ёсчлон баталгаажуулсан Ерөнхийлөгч Х.Баттулга өнөөдөр ч бүрэн эрхээ хэрэгжүүлнэ ажиллаж байна.

Түүнчлэн Улсын Их Хурал 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийг, 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг тус тус баталж, эдгээр хуулиараа Монгол Улсын иргэд эрхэлсэн ажил, албан тушаалаараа ялгарлагдахгүйгээр хуулийн өмнө эрх тэгш байж сонгогдох эрхээ хэрэгжүүлнэ гэдгийг тов тодорхой илэрхийлж баталгаажуулсан болно.

5. Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээнд хамаарахгүй асуудлаар Цэцийн гишүүн маргаан үүсгэн шалгаж байгаа бол иргэдийн өргөдөл, мэдээлэл нь ямагт үндэслэлгүйд тооцогдох бөгөөд үүнд хууль тогтоогчийн өмнөөс тухайлан тайлбар өгөх хууль зүйн шаардлага, үндэслэл байхгүй юм. Харин нэр бүхий иргэдийн өргөдөл, мэдээлэлдээ дурдсан Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уuguул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно” гэсэн заалтыг хууль тогтоогч Монгол Улсын Ерөнхийлөгчийн

сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.5, 3.1.9 дэх заалтууд, 5 дугаар зүйлийн 5.4, 5.6 дахь хэсэг болон 26 дугаар зүйлд тус тус тал бүрээс нь бүрэн гүйцэд зохицуулсан болохыг Үндсэн хуулийн цэцэд тайлбарлах нь зүйтэй байна.

Түүнчлэн Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргагч иргэний Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг нь Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг илэрхий зөрчсөн, “УИХ-аас ...баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд Үндсэн хуулийн энэ журмыг огт харгалзаагүй...”, “Монгол Улсын иргэнийг Ерөнхийлөгчөөр зөвхөн нэг удаа сонгоно гэсэн журмыг огт авч үзээгүй” гэх, мөн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэг буюу “Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хууль бусаар хязгаарлах, сонгогчоос саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хөндлөнгөөс нөлөөлөх, саад учруулахыг хориглоно” гэсэн нь Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг илэрхий зөрчсөн, “...Монгол Улсын Ерөнхийлөгчөөр одоо ажиллаж байгаа Х.Баттулгад 2021 оны Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд нэр дэвших эрхийг олгосон байна” хэмээх тайлбар, хуулийг нэг хүнд зориулж гаргах, эсхүл гаргасан мэтээр тайлбарласан зүйлүүд нь хууль зүйн хувьд ямар ч үндэслэлгүй бөгөөд энэхүү тайлбарын энэ хэсэг болон 3, 4 дэх хэсэгт тухайллан тайлбарласан үндэслэлээр тус тус бүрэн няцаагдана.

Хавсралт:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсэгт заасны Улсын Их Хурлын Тамгын газраас Ерөнхийлөгчийн Тамгын газарт албан ёсоор ирүүлсэн Монгол Улсын Их Хурлын 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 71, 72 дугаар тогтоол 04 хуудас;
2. Зөвшүүлцлийн Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн, тухайн үеийн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, өдгөө Хууль зүйн байнгын хорооны даргаар ажиллаж байгаа С.Бямбацогтын Төрийн ордонд хийсэн мэдээлэл CD 1 ширхэг.

